



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2017 оны 4 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 72

Улаанбаатар
хот

Итгэмжлэгдсэн төлөөлөгч
томилох тухай

1. “Зуун хаан” ХХК-ийн нэхэмжлэлтэй захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлөн оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга Н.Бат-Эрдэнэ нарыг томилсугай.

2. Итгэмжлэгдсэн төлөөлөгчид Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.1, 28.2-т заасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг нотлох баримттай танилцаж тэдгээрт тайлбар өгөх, хэргийн материалтай танилцах, түүнээс тэмдэглэл хийх, өмгөөлөгч сонгон авах, шүүх хуралдаанд оролцох, нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх буюу хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах, эвлэрэх, шүүхийн шийдвэрт давж заалдах, хяналтын журмаар гомдол гаргах болон хуульд заасан бусад эрхийг олгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ж.ЭРДЭНЭБАТ